

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 05 дугаар сарын 31-ний өдөр, Лхагва гараг**

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-5
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	6-21
<hr/>	
<i>1.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл /Засгийн газар 2023.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/</i>	6-16
<i>2.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл /Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	16-21

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 2023 оны
05 дугаар сарын 31-ний өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 15 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ё.Баатарбилэг, Ц.Мөнх-Оргил, Ж.Эрдэнэбат;
Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Мөнхцэцэг.

Нэг.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл /Засгийн газар 2023.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, дэд дарга С.Батбаатар, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Н.Мөнхзэсэм, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн референт Б.Галсанбат, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Бямбадулам нар байлцав.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Н.Энхболд танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Н.Энхболд хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 51.1.3, 51.2-т заасны дагуу дахин санал хураалгах шаардлагатай гэсэн горимын санал гаргав.

Н.Энхболд: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 14

Татгалзсан: 1

Бүгд: 15

93.3 хувийн буюу гуравны хоёроос доошгүйн саналаар горимын санал дэмжигдлээ.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Н.Энхболд: 1.Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Ш.Адъяаа, Ж.Батсуурь, Т.Доржханд, Х.Нямбаатар, Д.Сарангэрэл, Д.Тогтохсүрэн, О.Цогтгэрэл, Б.Энхбаяр /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсын Их Хурал нэг танхимтай, нэг зуун хорин зургаан гишүүнтэй байна. Улсын Их Хурлын сонгуулийг олныг төлөөлөх болон хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоогоор явуулна. Улсын Их Хурлын далан зургаан гишүүнийг олныг төлөөлөх, тавин гишүүнийг хувь тэнцүүлэн хуваарилах сонгуулийн аргын үндсэн дээр сонгоно.” гэснийг “Монгол Улсын Их Хурал нэг танхимтай, нэг зуун хорин зургаан гишүүнтэй байна. Улсын Их Хурлын сонгуулийг сонгуулийн холимог тогтолцоогоор явуулна. Улсын Их Хурлын далан найман гишүүнийг олныг төлөөлөх, дөчин найман гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно.” гэж өөрчлөн найруулах гэсэн саналыг дэмжье гэсэн 1 дэх санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 2
Бүгд: 15
86.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Н.Энхболд: Дээрх саналыг дэмжье гэсэн 2 дахь санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 0
Бүгд: 15
100.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг *Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд* Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 52 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл /Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, дэд дарга С.Батбаатар, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Н.Мөнхзэсэм, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн референт Б.Галсанбат, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Бямбадулам нар байлцав.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Н.Энхболд танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Н.Энхболд хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т “нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн” гэж заасны дагуу санал хураалт явуулав.

Н.Энхболд: Дахин санал хураалгах шаардлагатай гэсэн горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 0
Бүгд: 15
100.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Н.Энхболд: 1.Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Ш.Адъяаа, Ж.Батсуурь, Т.Доржханд, Х.Нямбаатар, Д.Сарангэрэл, Д.Тогтохсүрэн, О.Цогтгэрэл, Б.Энхбаяр /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн улс орон даяар дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 0
Бүгд: 15
100.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Н.Энхболд: 1 дүгээр заалт дэмжигдсэнтэй холбоотойгоор хоёрдугаар хэлэлцүүлгээс гарсан 5 дахь заалт үндсэндээ санал хураалгах шаардлагагүй гэж үзээд төслөөс нь хасъя гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 1
Бүгд: 15
93.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар үг хэлэв.

Н.Энхболд: Дээрх санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 1
Бүгд: 15
93.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Н.Энхболд: Дахин санал хураалгах шаардлагатай гэсэн горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 1
Бүгд: 15
93.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Н.Энхболд: Дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 0
Бүгд: 15
100.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Н.Энхболд: 2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “2023 оны дугаар сарын ...-ны өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөд нийцүүлэн холбогдох хуулийг шинэчлэн батлах хүртэл хугацаанд тухайн харилцааг зохицуулж ирсэн хуулийг дагаж мөрдөнө. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг үндэслэн олныг төлөөлөх /мажоритар/, хувь тэнцүүлэн хуваарилах /пропорционал/ тогтолцоог хослуулан явуулах зохицуулалтад Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг нийцүүлэх ажлыг Улсын Их Хурлаас баталсан хуваарийн дагуу хэлэлцэн шийдвэрлэнэ.” гэж хоёрдугаар хэлэлцүүлгээр дэмжсэн байсан саналыг “2023 оны 5 дугаар сарын ...-ны өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөд нийцүүлэн холбогдох хуульд өөрчлөлт оруулах болон шинэчлэн батлах хүртэл хугацаанд тухайн харилцааг зохицуулж ирсэн хуулийг дагаж мөрдөнө. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөд нийцүүлэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг 2023 оны 6 сарын 25-ны дотор, холбогдох бусад хууль тогтоомжийн өөрчлөлтийг Улсын Их Хурлаас баталсан хуваарийн дагуу хийж дуусгана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 0
Бүгд: 15
100.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д “нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед тухайн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулахгүйгээр уг асуудлыг гүйцээн боловсруулж, хуулийн төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулахаар Байнгын хороонд шилжүүлсэн” гэж заасны дагуу санал хураалт явуулав.

Н.Энхболд: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн дүнгээр байгуулагдах Улсын Их Хурлын бүрэн эрх хэрэгжиж эхлэх хүртэл 2020 оны ээлжит сонгуулийн дүнгээр байгуулагдсан Улсын Их Хурал бүрэн эрхээ хэвээр хадгална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 1
Бүгд: 15
93.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан үг хэлэв.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 05 минут үргэлжилж, 19 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 78.9 хувийн ирцтэйгээр 11 цаг 20 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Н.ЭНХБОЛД

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 05 дугаар сарын 31-ний өдөр,
Лхагва гараг

Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим 10 цаг 15 минут.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Энхболд: Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүддээ өглөөний мэнд хүргэе. Манай хороонд харьяалагддаг нийт гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн, ирц бүрдсэн учраас 2023 оны 5 сарын 31-ний өдрийн Байнгын хорооны хуралдаан нээснийг мэдэгдье.

Одоогийн байдлаар, энд ирцийн нэрс байдаг хаа байна. Тийм. Ганболд гишүүн, Сүхбаатар гишүүн, Амарсайхан гишүүн, Доржханд гишүүн, Оюунчимэг гишүүн, Тогтохсүрэн гишүүн, Занданшатар гишүүн, Энхболд гишүүн, Батсуурь гишүүн, Пүрэвдорж гишүүн, Бямбацогт гишүүн уг нь ирчихсэн, ирсэн байна. Сарангэрэл гишүүн ингээд 12 хүний бүрэлдэхүүнтэйгээр ирц бүрдсэн байна.

Хэлэлцэх асуудлаа танилцуулъя. Өнөөдөр Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хэлэлцэнэ. Засгийн газар 23 оны 5 сарын 3-ны өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх хэлэлцүүлэг Байнгын хорооны хуралдаанаар явагдана.

Мөн Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл хэлэлцэнэ. Засгийн газраас 23 оны 5 сарын 3-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг хийнэ. Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүн байна уу. Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Төрийн байгуулалтын байнгын хороо Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцдэг, гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэдэг дэгийн талаар танилцуулъя.

Нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлгээр Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний гурваас, Пүүжээ Пүүжээ чимээгүй бай л даа чи. Нийт гишүүний дөрөвний гурваас доошгүйн дэмжлэг авсан саналыг Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд нэмж тусгаад эцсийн хувилбар болгон гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай санал, дүгнэлт гаргах, мөн Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл, санал, дүгнэлтийг Байнгын хорооны гишүүдэд гурваас доошгүй хоногийн өмнө урьдчилан тарааж хуралдаанаар хэлэлцэнэ.

5.1.2-т заасан үндэслэлээр Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн зүйл, хэсэг, заалтыг баримтлан санал хураалт явуулна. Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар дэмжлэг авсан саналыг Байнгын хорооны санал, дүгнэлтэд тусгана.

Би гурав дахь хэлэлцүүлэгт бэлдсэн тухай ажлын хэсгийн танилцуулгыг та бүхэнд уншиж танилцуулъя. Миний ажлын хэсгийн юм хаа байна.

Эрхэм гишүүн Пүрэвдорж, Пүрэвдоржоо хурал битгий үймүүлээд байгаарай. Ярих юмаа дараа нь яриарай.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 23 оны 5 сарын 3-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 23 оны 5 сарын 19-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж,

төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн.

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо болон Тамгын газраас төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх хүрээнд Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг иргэдэд тайлбарлан таниулж, иргэдийн саналыг сонсох ажлыг улс орон даяар зохион байгуулсан.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг 23 оны 5 сарын 26-ны өдөр судлаачид, эрдэмтэд, хуульчид, Хэлний бодлогын үндэсний зөвлөл, Үндсэн хууль тогтоогчдын төлөөллийг оролцуулан өргөтгөсөн бүрэлдэхүүнтэйгээр хуралдсан бөгөөд 30-ны өдрийн хуралдаанаараа, нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлгээр санал хурааж шийдвэрлэсэн.

Монгол Улсын Их Хурал нэг танхимтай, нэг зуун хорин зургаан гишүүнтэй байна. Улсын Их Хурлын сонгуулийг олныг төлөөлөх болон хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоогоор явуулна. Улсын Их Хурлын далан зургаан гишүүнийг олныг төлөөлөх, тавин гишүүнийг хувь тэнцүүлэн хуваарилах сонгуулийн аргын үндсэн дээр сонгоно гэсэн саналыг Монгол Улсын Их Хурал нэг танхимтай, нэг зуун хорин зургаан гишүүнтэй байна. Улсын Их Хурлын сонгуулийг сонгуулийн холимог тогтолцоогоор явуулна. Улсын Их Хурлын далан найман гишүүнийг олныг төлөөлөх, дөчин найман гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно гэж өөрчлөн найруулах саналыг Байнгын хорооны хуралдаанаар ажлын хэсгийн гишүүд хэлэлцээд Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхийг дэмжсэн болно.

Түүнчлэн нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлгээр Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний гурваас доошгүйн дэмжлэг авсан саналыг Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд нэмж тусгасан төслийг та бүхэнд урьдчилан тараасан байгаа.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулга, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Гишүүдэд тарааж өгсөн материалуудтай танилцсан гэж бодож байна. Хүргүүлсэн байгаа төслийн эцсийн хувилбар, санал, дүгнэлттэй холбогдуулаад асуулт асуух гишүүн байна уу. Пүрэвдорж гишүүнээр тасаллаа. Пүрэвдорж гишүүний микрофоныг өгье.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр Их Хурлын гишүүдийн тоог нэмэх тухай асуудал яригдаж байна. Энэний ард бол мэдээж шударга сонгууль явуулах тухай асуудал хамгийн чухал асуудал байгаа. Тэгэхээр Ардчилсан намын бүлгээс сонгуулийн луйвартай урьдчилан сэргийлэх тухай хуулийн төслийг өргөн барихаар ажиллаж байгаа. Ер нь хэлэлцүүлэг хийхэд бол сонгуулийн гэмт хэрэгтэй тэмцэх тухай хууль гэж өөрчилж магадгүй. Ийм асуудлууд байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ сонгуулиа шударга явуулах нь хамгийн энэ ард түмний хүсээд байгаа гол зүйл байгаад байгаа юм. Энэ дээр би нэг зүйлийг л бас Ерөнхий сайд ороод ирчихсэн байна, Их Хурлын дарга сууж байна. Тэгэхээр нэг зүйлийг л би хүсээд байгаа юм. Өнөөдрийн байдлаар бол энэ Доминион

voting-гийн энэ хар машин бол программ хангамжийн хувьд асуудалтай, хугацаа нь хэтэрчихсэн ийм л зүйл байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ 2023 оны улсын төсөв дээр Сонгуулийн ерөнхий хорооноос нийтдээ 21 тэрбум төгрөгийн программ хангамжийн асуудлыг шийдвэрлэхээр төсөвт тусгаж оруулж, Засгийн газар дээр оруулах гэсэн боловч Засгийн газар энийг нь аваагүй. Дараа нь Төрийн байгуулалтын байнгын хороон дээр энэ асуудлыг Сонгуулийн ерөнхий хороо оруулж ирсэн боловч харамсалтай нь Сонгуулийн ерөнхий хорооны энэ саналыг дэмжээгүй. Тун удахгүй манай ард түмний бас энэ шаардлагын дагуу улсын төсвийн тодотгол явагдаж энэ хүүхдийн мөнгийг 100 хувь болгох, мөн түүнчлэн цалин, тэтгэвэр нэмэх тухай асуудлыг шийдвэрлэж байгаа.

Тэгэхээр энэ төсвийн тодотголоор энэ Доминион voting-гийн энэ сонгуулийн машиныг, тоолох машины программ хангамжийн асуудлыг шийдвэрлэж өгөөч гэдэг л ийм л ганцхан хүсэлт байгаа юм. Энэ асуудал дээр бас тодорхой хэмжээгээр би мэдээж дэгээр бол Их Хурлын дарга, Ерөнхий сайд хариулах боломж байхгүй. Тэгэхдээ хоёр дарга хоёулаа бол миний албан бус байдлаар бас асуухад хоёулаа толгой тохисон. Тийм учраас энэ асуудлыг, энэ асуудлыг улсын төсвийн тодотголоор шийднэ гэж би бас ойлголоо.

Тэгэхээр бид нар бол хамгийн гол нь сонгуулийн ямар ч систем байж болно. Сайн систем байж болно, муу ч систем байж болно. Тэгэхдээ тэр хамгийн гол нь шударгаар тэрийг тоолох тухай асуудал л хамгийн гол асуудал байхгүй юу даа. Яах вэ ард түмэн эргэлзээгүй, ямарваа нэгэн асуудалгүй, тэрэндээ итгэдэг ийм сонгуулийг явуулах асуудал хамгийн гол бидний хүсээд байгаа гол зүйл байгаад байгаа юм. Ард түмний ч хүсээд байгаа гол зүйл.

Тийм учраас энэ 21 тэрбум төгрөгийг улсын төсөв дээр тавих тухай асуудлыг энэ төсвийн тодотголоор шийдэж өгөөрэй л гэж би та бүхэнд хүсмээр байна. Тэгээд дэгээр Их Хурлын дарга, Ерөнхий сайд хариулах боломжгүй учраас хэн хариулах ёстой юм. Тэн дээр хариулт өгөөч. Би энэ хуулийг өргөн барьсан бүлгийн дарга Тогтохсүрэн дарга бас энд хариулах боломжтой гэж үзэж байна.

Н.Энхболд:

Баярлалаа.

Сонгуулийн хуулийг энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт эцэслээд шийдэгдвэл энэний дараа Сонгуулийн хууль хамгийн түрүүн, хамгийн түрүүн хийхээр, өөрчлөхөөр оруулаад төлөвлөчихсөн байгаа. Ажлын хэсгийг нь Ардын намын бүлгийн дарга Тогтохсүрэн хариуцаж байгаа.

Мэдээж аливаа сонгууль ямар ч байдлаар, ямар ч журам, хуулиар явсан эцсийн дүндээ түүний легитим чанар нь баталгаатай байх бол тэр сонгуулийн ажлын хамгийн чухал үр дүн. Тийм учраас энэ Пүрэвдорж гишүүний ярьж байгаа асуудлыг Сонгуулийн хууль яригдах үеэр мэдээж Сонгуулийн хуулийн ажлын хэсэг ч тэр, Сонгуулийн ерөнхий хороо ч тэр, Их Хурал, Засгийн газрын зүгээс ч тэр онцгой анхаарах болно гэдэг нь угаасаа, угаасаа ойлгомжтой асуудал. Ингээд яах юм бэ одоо энэ дээр хэлэлцэж байгаа асуудлынхаа хүрээнд яримаар байна Их Хурлын даргаа. Дараа нь үг хэлнэ. Тийм. Гишүүд асуулт асууж дууслаа.

Одоо саналтай гишүүн байвал нэрээ өгье. Сүхбаатар гишүүнээр, Батсуурь гишүүнээр тасаллаа. Занданшатар дарга.

Г.Занданшатар:

Гишүүдийн

өдрийн амгаланг айлтгая. Сая бас Пүрэвдорж гишүүний хөндсөн асуудлаар хэдийгээр Үндсэн хуульд оруулах өөрчлөлттэй шууд холбоогүй ч гэсэн энэ сонгуулийн тогтолцоо, гишүүдийн тоо,

энэ сонгуулийг шударга, зөв явуулах асуудалтай холбогдож байгаа учраас энэ тавигдаж байгаа асуудал бас төсвийн тодотголтой хамт шийдэгдэх ёстой, бас Үндсэн хуулийн өөрчлөлтийг орсонтой холбогдуулаад Сонгуулийн хуульд өөрчлөлт орох ёстой.

Тэгэхээр энэ Дагаж мөрдөх журмын тухай хууль энэ тэр дээрээ энэ асуудлыг бас харгалзан үзэхээр тусгавал, Пүрэвдорж гишүүний саналаар тусгавал Сонгуулийн ерөнхий хорооноос тодруулаа л даа сая би. Сонгуулийн ерөнхий хороо бол программ хангамжийн асуудал биш хар машины асуудлаа шинэчлэх хугацаа нь дуусчихсан, лиценз нь дуусчихсан. Тэгэхээр энийг хар машинтайгаа хамт программ нь шинэчлэгддэг юм байна. Тийм, тийм учраас энэ асуудлыг цогцоор нь шийдэхгүй бол бас энэ болохгүй гэж байгаа учраас энийг бас протоколд тэмдэглүүлээд, Пүрэвдорж гишүүний саналаар энэ Үндсэн хуульд оруулах өөрчлөлт, дагалдан гарах Сонгуулийн хууль, бусад асуудалтайгаа шийдэх нь бол зүйтэй гэсэн ийм зарчмын асуудал энд протоколд тэмдэглүүлж хэлэх нь зүйтэй байх гэж бодсон учраас Сонгуулийн ерөнхий хорооны саналыг аваад энэ асуудлыг шийдэх талаар энэ төсөв өргөн барихдаа болон асуудал шийдэхгүй бол өнгөрсөн онд төсвийн төсөвт өргөн баригдаад шийдэгдээгүй яваад байгаа юм байна. Тийм учраас энэ цаг хугацааны асуудал учраас энд бас тэмдэглэж хэлэх нь зүйтэй байх. Пүрэвдорж гишүүний саналаар энэ асуудлыг бас тусгаж авах нь зүйтэй байх. Яагаад гэвэл энэ бас улс төрийн намын саналаар нь авч үзье.

Н.Энхболд: Баярлалаа. Оюун-Эрдэнэ Ерөнхий сайд.

Л.Оюун-Эрдэнэ: Өнөөдөр Үндсэн хуулийн сонгуулийн тогтолцоотой холбоотой эцсийн хэлэлцүүлэг явагдаж байна. Бид 30 жилийн өмнө тогтсон ийм тоглоомын дүрмээр улс төрийн намууд

сонгууль дөхөөд ирэхээр өөрөө өөртөө зориулсан ийм тоглоомын дүрмийг Сонгуулийн хуулиар хийж 30 жил явлаа. Үүнээс болж урт хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлт өнгөрсөн 30 жилийн хугацаанд бүхэлдээ алдагдсан гэж үзэж болно. Нэг Их Хурлын гишүүн дээр байгаа эрх мэдлийн жин үлэмж хэмжээгээр өндөр байдаг учраас хууль тогтоох байгууллагын үйл ажиллагаанд оролцохоос эхлээд, олон Байнгын хорооны гишүүн байхаас эхлээд олон асуудал дээр кнопны энэ жин бол туйлын чухал байсаар ирсэн. Бие биедээ хариуцлага тооцох боломжгүй. Кноп нь бага учраас. Их Хурлын гишүүд томилолтоор явбал бараг чуулган гацах хэмжээнд ийм том эрх мэдлийн төвлөрөлтэй. VIP далан зургаа гэдгээс авхуулаад, нэршилээсээ авхуулаад л энэ далан зургаан парламентын гишүүнийг бол эрх мэдлийн хамгийн оргил дээр байдаг цэг гэж ойлгодог болсон. Гишүүн бүхнийг гүйцэтгэх засаглалын ажил хийх энэ агуулга руу явж Монгол Улс бүхэлдээ далан зургаан Ерөнхий сайдтай болж хувирсан. Энэ бүх зүйлээс болж санал хураалт болгон дээр, төсөв өргөн баригдах бүхэн дээр, улс төрийн томоохон асуудал болох бүр дээр, эсвэл зээл байдлаар ч юм уу, эсвэл тендер байдлаар ч юм уу ийм наймаа явдаг, барьцаанд ордог, бойкот хийдэг ийм нөхцөл байдал ингээд 30 жилийн хугацаанд хуралдан бий болсон. Энэ бол нууц биш.

Өнөөдөр би Их Хурлын гишүүддээ бас талархаж байна. Яагаад гэхлээр энэ дээр зоригтой шийдэл гаргаад энэ эрх мэдлийн хэт төвлөрлийг задлах шийдвэр гарч байгаа юм. Энэ Үндсэн хууль батлагдсанаар цаашидаа Их Хурлын гишүүн байна гэдэг бол тийм ч сонирхолтой зүйл биш болж хувирна. Бизнесийн зарчмаар энд орж ирэх ямар ч ашиггүй болж хувирна. Энэ Ашиг сонирхлын тухай хууль батлагдчихвал. Яг л түмнээ төлөөлөх зарчмаар олон нийтийн төлөөлөгч болох энэхүү суурь зарчим энд биеллээ олно. Илүү бас

иргэдийн төлөөллүүд орж ирэх боломж гарна. Яах вэ хүмүүс бас ярьж байна л даа жагсаалтад нэр муутай хүмүүсийг оруулж ирвэл гээд. Тэгж байгаа нам шууд ялагдах ёстой. Хоёр сонгууль дээр ялагдаад л дүгнэлт хийнэ.

Тийм учраас энэ 30 жилийн хугацаанд явж ирсэн авлигал, ашиг сонирхолтой холбоотой, ил далд лоббитой холбоотой энэ бүх асуудал уг нь бол зуун тавин хоёр байсан бол 2 дахин багасах байсан. Гэхдээ мэдээж Үндсэн хууль зөвшилцлөөр явдаг учраас Ардчилсан намын Үндэсний бодлогын хорооны гарсан шийдвэрийн дагуу өнөөдөр зуун хорин зургаагаар эцсийн хэлэлцүүлэг хийгдэж байна. Бид хүндэтгэлтэй хандаж байна. Бусад улс төрийн намууддаа ч гэсэн бас хүндэтгэлтэй хандаж байна.

Сая бас Пүрэвдорж гишүүний хөндсөн асуудлыг бид нар нэлээн анхааралтай хандъя. Ер нь бол сонгууль хэл амгүй, шударга болох ёстой. Хилийн чанадад байгаа Монголчуудаа бид нар сонгуульд оролцуулах ёстой. Сонгуулийн ирц аль болохоор өндөр байх ёстой. Цаашидаа бид нар цахимаар сонгууль хийдэг зүйл рүү явах учиртай. Ингэж байж санал гээгдэхгүй, төлөөлж байгаа төрийн легитим сайн байх ёстой. Хүлээн зөвшөөрөгдөх байдал өндөр байх ёстой. Ингэж байж илүү хүртээмжтэй ардчилал бий болгох бас энэ агуулга тавигдана.

Тэгэхээр энийг яах вэ мэдээж мэргэжлийн байгууллагуудаас нь хэдүүлээ судалж асууя. Зүгээр сонгуультай холбоотой, сонгууль шударга байх, эргэлзээгүй байх энэ бүх асуудал дээр бид нар сөрөг хүчиндээ байнга хүндэтгэлтэй хандана. Байнга хүндэтгэлтэй хандана. Би бас хэлсэн та бүхний яг хүссэн дүрмээр чинь, яг хүссэн эрх зүйн орчноор чинь бид өрсөлдөнө. Яагаад гэхлээр тэгэх ёстой юм байна лээ. Тэгж байж энэ маань өөрөө хяналт,

тэнцэл сайн, илүү сонгуулийн маргаан байхгүй ийм агуулгаараа ингээд явна.

Цаашилаад тойрог хуваарилах нөхцөл байдал, залгаад Сонгуулийн хууль, залгаад Улс төрийн намын тухай хууль дээр ч гэсэн бид нар парламентад суудалтай байгаа Ардчилсан нам, Хүн нам болон бусад улс төрийн намын саналыг бид нар илүү хүндэтгэнэ. Ямар нэгэн байдлаар хүч түрсэн тийм алхмыг бол бид нар хийхгүй. Энэ нь өөрөө сонгууль шударга байх, технологийн хувьд, мөн дүрэм журмын хувьд, хууль тайлбарлах, хуулийг нэг мөр ойлгох энэ бүх асуудал дээр бол хамтдаа ярилцаад явчхаж болно.

Нөгөө талаараа энэ Үндсэн хууль батлагдсанаар энэ бол өөрөө нэг нам илэрхий давамгайлж ялахгүйгээр илүү консенсус буюу зөвшилцлийн ардчилал руу орно гэсэн үг. Яг Германтай төстэй байдлаар. Энэ бол өөрөө улс төрийн намуудад бодлогын нам болж төлөвшихөд түүхэн ийм чухал хувь нэмэр бас болно гэж бол итгэлтэй байгаа.

Тэгээд энэ дээр өнөөдөр бас парламентын гишүүдийн хувьд бол хэдийгээр яах вэ ингээд яг зуун тавин хоёрроор биш ч гэсэн өнөөдөр далан найм, дөчин найм гэсэн энэ пропорцоор энэ асуудал шийдэгдвэл Монгол Улсад шинэ 30 жил, авлигагүй 30 жил, ашиг сонирхлоос ангид байх 30 жил, эрх мэдэл хэт төвлөрсөн биш 30 жил эхлэх суурь реформ болж байна гэж үзэж болно. Суурь реформ. Мэдээж яах вэ Засгийн газар, Их Хурал ч авлигатай тэмцэх ажлуудыг эрчимтэй хийж байна. Одоо бол бид нар ийм хөрсөн дээр ургасан ургамалтай л тэмцээд байгаа юм. Суурь хөрсийг нь засахгүй бол тийм ургамал ургасаар л байх болно.

Тийм учраас өнөөдөр бол хөрсийг нь бүхэлд нь өөрчлөх маш том реформын үндсэн эхлэл бол өнөөдөр бас энэ танхимд ингээд тавигдаж байна гэдэг агуулгаар бол баяртай байна. Энийг би

бас тэгээд протоколд тэмдэглүүлэн үлдэх нь бол өөрөө чухал зүйл байх байх. 2019 онд хийгдэх ёстой байсан зүйл. Харамсалтай нь санал хураалтаар тухайн үед унасан. Эрт, орой хэзээ нэгэн цагт хийх зүйлийг бид цаг алдахгүйгээр заавал хийх ёстой. Яагаад гэхлээр дараагийн хүмүүстээ бид нар зовлон үлдээхгүйн тулд хийх ёстой. Зовлон байвал бид нар цаг хугацаа цаг хугацаандаа л эс үйлдэл хийхгүйгээр шийдэх ёстой. Тэгэхгүй бол галаас зугтаагаад эсвэл ингэчихвэл яаж шүүмжлэгдэх бол, ингэчихвэл яах бол гэж явсаар байтал манайд маш их олон асуудлууд хуримтлагдсан.

Тийм учраас хуримтлагдсан асуудлуудыг бид нар цогцоор нь, суурь реформоор нь шийдэж чадвал дараа дараагийн ажиллах хүмүүс энэ цаг үе өөрөө зөвөөр үнэлэгдэх ийм өдөр ирнэ гэдэгт итгэлтэй байна. Энэ дээр би тэгээд Ардчилсан нам, бас Хүн намын удирдлагууд, бусад улс төрийн намууд дуу хоолойгоо илэрхийлсээр ирсэн Иргэний нийгмийн байгууллагууд, олон эрдэмтэн, судлаачдад би бас өнөөдөр бол та хэд туйлын чухал зүйл дээр маш зоригтой ийм том реформыг хийж байна гэдэг агуулга дээр нь бас талархал илэрхийлэх нь зүйтэй гэж бодож байна.

Н.Энхболд: Сүхбаатар гишүүний микрофоныг өгье.

Ж.Сүхбаатар: Би бас энэ түүхэн Ерөнхий сайдын хэлсэн түүхэн энэ том эхлэл, өөрчлөлтийн энэ асуудал дээр бас байр сууриа илэрхийлье гэж бодсон юм саналаа. 12 жилийн өмнө Улсын Их Хурлын дарга Дэмбэрэл дарга надад үүрэг өгөөд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг бэлтгэх, энд судалж үзэх ажлын хэсгийг 50 гишүүнтэй байгуулж, би ажлын хэсгийн ахлагчаар нь Төрийн байгуулалтын байнгын даргын хувьд ажиллаж байсан юм. Тэгээд тэр үед цаг хугацааны боломж Сонгуулийн хуулийн асуудал хэлэлцэж байсан учраас цаг хугацааны боломж бас шахагдаад,

шавхагдаад ингээд бид бол тодорхой тандалт судалгаа, хэлэлцүүлэг, элдэв юм хийсэн юмнуудаа дараачийн парламент хүлээлгэж өгч байна гээд ингээд шилжүүлсэн. 12-16 оны парламент 2 ажлын хэсэг гаргаж яг энэ бид нарын хийсэн ажлыг авч явсан. Дараа нь 16 оны парламент бас дахиад 2 ажлын хэсэг гаргасан. Ингээд 2019 оны нэмэлт, өөрчлөлтийг, Үндсэн хуульд оруулсан нэмэлт засварыг бол Занданишатар даргын үед бол хийсэн. Тэр үеийн улс төрийн үндсэн том зөвшилцлөөр олон чухал асуудлууд бол шийдэгдсэн.

Гэхдээ шийдэгдэж үлдэж чадаагүй асуудлууд бол үлдсэн. Би тэрийг бол Өдрийн сонинд өгсөн ярилцлагадаа маш том ажил хийлээ. Гэхдээ хүсэн хүлээсэн ажлынхаа 70 хувийг хийлээ гэдэг зүйлийг бол тухайн үед хэлж байсан. Одоо бид олон зүйлүүдийг хийсэн гэж.

Тэгэхээр энэ удаа бид бол энэ 100 хувийн ажлынхаа бас 20 хувийг хийх гэж байна. 10 хувь нь бол энэ удаа бол амжихгүй байх шиг байна. Ер нь бол Үндсэн хууль гэдэг бол цаг үеийнхээ үргэлжлэл дээр, зөвшилцөл дээр, ойлголцол дээр, огтлолцол дээр шийдэгддэг ийм ажил. Энийг хэн нэгэн хүн хүсээд юм уу, хүчиндээд, муйхарлаад хийж болдоггүй ийм ажил. Өнөөдрийн одоо энэ Үндсэн хуулийн нэмэлт засварын асуудал бол Улсын Их Хурал дээр, Улсын Их Хуралд суудалтай Хүн нам, Улсын Их Хуралд суудалтай Ардчилсан нам, Улсын Их Хуралд суудалгүй боловч улс төрийн олон намууд эрх баригч Монгол Ардын намтай улс төрийн түвшинд олон удаагийн яриа хэлэлцээ хийгдэж байсан.

Ер нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг бид бас зах замбараагүй явуулахгүйн тулд одоогоос 13 жилийн өмнө Энхтүвшин дарга, Сайханбилиг бид нар гээд санаачилж, Чимэд багш бас боловсруулж орж ирсэн Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль байгаа. Энэ хууль бол төрийн

юмыг олон иргэд санаачилж, санаачилга гаргаж болно. Улс төр төрийн түвшинд замбараагүй явж болохгүй. Энэ бол төр улсыг үймүүлэх эрсдэлтэй учраас энэ журмын тухай хуулиар хатуу явах ёстой гэдэг ийм хуулийн нарийн хашлага, хашааг бол хийж өгсөн.

Энэ хуулийн хүрээнд бол өнөөдөр энэ нөгөө процесс үргэлжилж явж байгаа гэж ингэж үзэж байгаа. Тэгэхээр өнөөдрийн хамгийн гол юм бол би цохож хэлэх гэж байгаа юм нь 19 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт бол үр дүнгээ өгч байгаа. Тухайлах юм бол бид ард түмний засаглах бүрэн эрхийг хангана гээд, ил тод иргэдийн мэдээлэлд мэдэх эрхийг хангаж өгөх тухай заалт хийсэн. Дээр нь бид намуудын ардчилсан дотоод зохион байгуулалт, ил тод байх тухай асуудлыг зааж өгсөн. Нийтийн мэдээллийн ил тод байдлын хуулийг Улсын Их Хурал сая баталлаа шүү дээ. Тэр ил тод байдал гэдэг үгийг би зарчмын зөрүүтэй санал гаргаж нэмсэн жишээлбэл. Тэгэхээр энэ чинь 19 оны Үндсэн хуулийн амин сүнс, үзэл санаа, хэрэгжих процесс явж байгаа. Энийг гүйцээх, дутуугаа гүйцээж байгаа энэ зүйл бол өнөөдрийн орж ирж байгаа зүйл юм гэж ойлговол сая зөв болно.

Миний хувьд дэмжиж байгаа гол юм нь бол өнөөдрийн геополитикийн үндэслэл, шаардлага, өнөөдрийн нийгэм, улс төрийн амьдралын шаардлага, эдийн засгийн шаардлага, хууль зүйн шаардлага гэсэн ийм 4 үндсэн шаардлага дээр бол бид нөхцөлдөж энийг олон хүн дургүйцэж байсан ч гэсэн өнөөдөр эрх баригч хүчний удирдлага, улс төрийн манлайлаараа эрсдэлээ үүрээд, тэгэхдээ ирээдүйгээ та сая хэлж байна дараачийн, магадгүй энэ Үндсэн хуульд оруулж байгаа бидний сонгуулийн тогтолцооны үр дүн, үр дагавар, ид шид гэж ярих юм бол 28, 32 оноос илүү их хүчтэй нөлөөлөл үзнэ.

Ер нь бол сонгуулийн шинэ хууль, тогтолцоо бол хоёр дахь, гурав дахь

сонгуулиасаа илүү үр дүн үзүүлнэ. Харамсалтай нь бид 2012 оныхоо сонгуулийн тогтолцооны ид шидийг 1 удаа сонгууль хийж үзээд, тэгээд өөрчлөөд явчихсан. Тэгэхээр ийм тэвчээргүй улс төрийн хувьд харалган бас байж болохгүй гэдэг сургамж бол байсан. Тэр үед энэ Сонгуулийн хуулийг хийж байсан улсууд нь энэ Нямаа Энхболд дарга бид 2 байж байна.

Гэтэл энэ хуулийн үзэл санаа дэвшилттэй байсан. Тэр нь яах вэ Үндсэн хуулийн цэц, дараагийнх нь улс төрийн намуудын тухайн үеийн удирдлагуудын балгаар энэ дэвшилттэй юмыг сайжруулах байсныг нь нурааж хаясан. Нураасныхаа горд өнөөдөр бид энэ парламентыг өнөөдөр нийгэм яриад байна шүү дээ. Та бүхэн бүрэн төлөөлж чадахгүй байна, нэг нам бүх суудлыг хамж байна. Гэтэл сонгогчдынхоо 50 хувийн саналыг авч чадахгүй байхад энэ олон иргэдийн санал гээгдэж байна. Энэ парламент чинь худалч, хулгайч нар дүүрчихлээ гээд яриад байгаа чинь яг үнэндээ бол олон хүн асуудалд холбогдоод байгаа гэж байгаа нь тогтолцоо нь цөөн хүнд эрх мэдэл төвлөрсөн байж байгаа гэдгийг харуулж байгаа юм.

Тэгэхээр би ардчиллын гол дүрэм бол цөөн хүн нэг нам дангаараа засагладаг хэт парламентын олонх зонхилсон нам гэдэг бол парламентын бас диктатур үүсгэдэг гэдэг ийм яриа байдаг. Цөөнхийн дарангуйллаас дутахгүй байдал үүсгэдэг. Тэгэхээр 2 удаа эрх баригч болсон нам өөрөө либералчлал, сонгуулийн либералчлалыг Үндсэн хуулийн олонх байгаа өөрийнхөө хоёр дахь боломжоо эдэлж байгаагийн хувьд Үндсэн хуулийн өөрчлөлт оруулах эрхээ эдэлж, энэ утгаараа энэ өөрчлөлтийг оруулъя гэж. Мэдээж зуун хорин зургаа дээр бол манай намын гишүүд дотор олон янзын санал, бодол бол байгаа. Ерэн ес байх ёстой, зуун найм байх ёстой, зуун хорин зургаа, зуун тавин хоёр, зуун гучин дөрөв гэдэг ч юм уу ингээд байх ёстой гэдэг хүмүүс бол

байна. Нийгмийн уур амьсгал ч гэсэн ийм байна.

Гэхдээ эцсийн дүндээ хууль тогтоогчид олон түмнийхээ санаа бодол дээр харгалзаж, үндэслээд бас эцсийн шийдлээ ард түмнийхээ ирээдүйг харж, Монгол төрийн удирдлагын арга ухаанаа онолын үндэслэлтэйгээр авч үзэж байгаад шийдэх ёстой. Дэлхий дахины жишиг юу байна вэ гэхээр цөөн хүмүүс хоорондоо хуйвалдах боломж нь эрх мэдлийн орчинд их байдаг юм байна. Угаасаа эрх мэдлийн орчин бол тодорхой орсон ямар ч сайн хүнийг ялзруулж ирдэг. Ямар сайндаа л сануулж хэлэх хүнгүй бол сайн засаг ялзарна гэдэг шиг цөөн хүнд найддаг сайн хүмүүсийг гаргаж ирнэ гэсэн энэ мажоритар далан зургаа дотор бид хий эргээд, тэгээд муу нэртэй парламентаа бий болгоод удахгүй парламентын засаглалаа хэрэггүй гэдэг юм руу орох гээд байна шүү дээ. Долоон хүнд засгийн эрх өгье, Ерөнхийлөгчийн засаглалтай больё, гучин хүнд удирдуулъя, хорин сайн хүнийг гаргая гэж. Дэлхий дээр тийм юм байхгүй л байна л даа. Сайн хаантай байж болж байгаа байх.

Тэгэхээр ийм нэг тогтолцоогоо засъя гэж байгаа юман дээр жишээлбэл би яагаад дэмжиж байгаа юм бэ гэхээр 28, 32 оны дараа дараачийн парламент, дараачийнхаа үеийнхэн энийг үздэг юм байна лээ. Ерөнхий сайд энэ өнгөрсөн Үндсэн хуулийг хэлэлцэж байх үеийн юмыг анх удаа олон ботиор тэр хэвлэж гаргасан юм. Тэрийг уншсан. Олон ухаантай хүмүүс тэр үед хэлж байсан юм байна лээ шүү дээ. Энэ Улаанбаатарын хэт төвлөрөл чинь бий болох нь байна, хотуудын хөгжлийн асуудал яачхав, энэ гишүүдийн тоо чинь цөөн байна, энэ парламент чинь өөрөө цөөн хүний хүрээнд ингээд ороод балрах юм байна, ард түмнийг төлөөлж чадахгүй юм байна ч гэдэг юм уу. Тэр цөөн хүний хэлсэн үгийг тэр олон хүн тухайн үедээ бас сонсоогүй боловч тэр

цөөн хүний өнөөдрийн үзэл санаа өнөөдөр бидэнд үнэтэй байгаа байхгүй юу.

Тэгэхээр миний хэлж байгаа юм бол Ток Филийн нэг үг байгаа юм. Ардчилсан улс орон болгонд шинэ үе гэдэг бол шинэ ард түмэн байдаг гэж байгаа юм. Бид нэг зүйлтэй бас хүлээн зөвшөөрөх ёстой. Шилжилтийн үеийн цаг үеийг тодорхойлж явсан улс төрийн эрин цаг үе удахгүй дуусах нь. Тэр дуусахад нь юу хэрэгтэй юм бэ гэхээр Үндсэн хуулийн шинэ дүрэм, сонгуулийн шинэ дүрэм, улс төрийн шинэ дүрэм байж байгаа юм. Шинэ дүрэм бол шинэ цаг, шинэ үе, шинэ зорилтыг авчирна гэж. Тэгэхээр шинэ сэргэлт гэдэг бол би ойлгохдоо шинэ хандлага гэдэг бол энэнтэй холбоотой гэж ойлгож байгаа учраас өнөөдрийн хамгийн өнөөдрийн түүхэн бид өөрчлөлтийг хийж байгаа. Энэ дээр дургүйцэж, шүүмжилж, мэдээж энэ бол ардчилсан орон учраас бүгд барина. Би энэ зуун хорин зургаа дээр жишээлбэл юу гэдэг юм өөрийн хувийн байр суурийг илэрхийлэхгүй байгаа. 13 жилийн өмнө бол би 99 гээд анх дуугарсан хүн нь мөн.

Гэхдээ өнөөдрийн байдлаар энэ хүрээнд олон хүмүүсийн үзэл, огтлолцол дээр улс төрийн намуудын ойлголцол, зөвшилцөл, олон процессыг туулсаар байгаад энэ хүрлээ. Энэ бол одоо бас бидний хувьд бол энийгээ алдагдуулахгүй яаж урагшлах вэ. Мэдээж энэний дараа маш их шүүмжлэл ирнэ.

Гэхдээ бидэнд хийх ажил үлдэж байгаа. Сонгуулийн хуулиа зөв сайн гаргах асуудал байж байна. Улс төрийн намын тухай хуулиа гаргах асуудал байж байна. Улсын Их Хурлын дэгээ сайжруулах асуудал байж байна. Одоо Их Хурлын гишүүдийг чангатгах тухай асуудал байж байна. Сонирхлын зөрчлийн хуулиар Их Хурлын гишүүдийн эрхийг л хязгаарлаад байгаа шүү дээ бид. Сайн засаг гэдэг бол өөрийнхөө эрхийг л хязгаарладаг байх ёстой.

Тэгэхээр Улсын Их Хурлын гишүүдийн тэр эрх дарх, халдашгүй байдалд хүмүүс дургүйцээд байна. Тэгвэл тэр эрхийг чинь олуулаа болоод ирэхээр Их Хурлын гишүүний үг хэлэх эрх чинь багасаж байгаа юм. Ялангуяа нэгдсэн хуралдаан дээр. Байнгын хороон дээр жишээлбэл ажил хэрэгч хандлага нь орно. Дээр нь гишүүд тойрогтоо ажиллах боломж нь нэмэгдэнэ гэдэг ч юм уу. Ингээд би энэ болгоныг бол протоколд үлдээхдээ юу бодож хэлж байна вэ гэхээр Монгол төр гэдэг бол тэр Чимэд багшийн хэлснээр тэр ухаалаг парламенттай, зөв хууль гаргадаг парламенттай, тэр хуулийг нь зөв хэрэглэдэг шүүхтэй, сайн гүйцэтгэдэг Засгийн газартай болох ёстой. Тэгж гэмээ сайн засаглал бий болно гэж байгаа юм.

Тэгэхээр Улсын Их Хурал өөрийгөө иргэдийн шүүмжлэл Улсын Их Хурал дээр маш их ирээд байгаа байхгүй юу. Тэгэхээр бид хуучин дүрмээрээ байгаагаараа дараагийн сонгуульд орно гэх юм бол иргэд биднийг зөв ажилласан гэхгүй. Биднийг юм хийхгүй байна гэж шүүмжилж байна, төлөөлж чадахгүй байна гэж шүүмжилж байна. Бас өөрчлөх гэж байгаа дээр зарим нь санал нийлэхгүй байна гэж шүүмжилж байна.

Гэхдээ бид ардчилсан улс орон учраас л ингээд явж байна. Тэгээд хууль тогтоох байгууллага шийдвэрээ гаргах ёстой. Би тэгээд ийм учраас энэ дээр бол өнөөдрийн энэ хүрсэн энэ ололт, амжилт дээрээ тулгуурлаад явах ёстой. Мэдээж Их Хурлын гишүүдийн энэ гарч байгаа шийдлүүд дээр олон хүн дургүйцэх юм байна.

Гэхдээ өнөөдрийн энэ шийдэл бол хувь гишүүний шийдлүүд биш шүү. Өнөөдөр энэ Улсын Их Хуралд суудалтай байгаа, гурван Улсын Их Хуралд суудалтай нам өөрөө улс төрийн шийдвэрээ гаргаж тулганы гурван чулуу болж, улс төрийн хариуцлага, эрсдэлээ үүрч, ирээдүйг харж ингэж шийдвэрээ

гаргаж байна гэж ингэж ойлгож, энд нь санал нэгтэй бас тодорхой Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн гишүүнийхээ хувьд, дотоод бид нар дотроо бол зөндөө маргасан, ярьсан, иргэдтэй уулзсан, санал шүүмжлэл өрнөсөн, шүүмж бид нарын эсрэг санал бодол гаргасан хүмүүс бий. Бид бас тайлбарласан.

Гэхдээ дэлхий дахинд тогтсон төрийн удирдлагын арга ухаанаар парламент нь зуун хориос зуун гучин гишүүнтэй байх юм бол цөөн хүн засагладаггүй юм байна гэдэг энэ философи дээр бид нэгдэж байгаа шүү. Тэгээд тэр санал хураах машин дээр Доминионгийн хүчинд чинь.../минут дуусав./

Н.Энхболд: Гишүүд ажлын хэсгийн танилцуулга, тараасан хуулийн томъёололтой холбогдуулж үг хэлж дууслаа.

Одоо санал хураалт явуулна. Гишүүд анхааралтай сонсоорой. Пүрэвдоржоо. Санал хураалт явуулахаас өмнө холбогдох хуулийн заалтуудыг уншиж танилцуулъя. Гишүүд ээ анхааралтай сонсоорой.

Гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэхдээ Байнгын хороо санал хураалт явуулж болно. Хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар хэлэлцэж шийдвэрлэнэ. Хоёр дахь хэлэлцүүлгээр санал хурааж шийдвэрлэсэн боловч уг асуудлаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн бол, эс үгүй бол нэмэлт, өөрчлөлтийн төслийн зүйл, хэсэг, заалтад найруулгын засвар хийсэн бол, мөн Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүний гуравны хоёроос доошгүй нь дэмжлэг аваагүй бол зарчмын зөрүүтэй саналыг төсөлд тусгах шаардлагагүй гэж үзсэн үндэслэл, шалтгаанаа Байнгын хорооны санал,

дүгнэлтэд тусгана гэсэн ийм дүгнэлт байгаа.

Тэгэхээр мөн хуулийн 51.1.3, 51.2-т зааснаас бусад үндэслэлээр нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлгээр дэмжигдсэн саналыг өөрчлөх буюу хүчингүй болгох санал, дүгнэлт гаргахыг хориглоно гэсэн ийм дэгийн заалтууд байгаа.

Одоо ингээд хэдийгээр хоёрдугаар хэлэлцүүлгээр дэмжсэн ч гэсэн Байнгын хорооноос санал гаргаж байна. Горимын санал.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн нэгдүгээр зүйлийг 23-ны 5 сарын 19-ний өдрийн нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлгээр санал хурааж шийдвэрлэсэн боловч уг асуудлаар дахин санал хураалгай гэсэн томъёоллоор Үндсэн хууль яригдаж байгаа учраас бид нар энэ зүйлүүдээ их баталгаатай, найдвартай, дараа нь янз бүрийн маргаан гаргахааргүй хийх шаардлагатай байна.

Ийм учраас ийм горимын саналаар саналуудаа гуравны хоёроор дахиад гурав дахь хэлэлцүүлгээрээ хураагаад, шийдээд явчихъя гэсэн томъёоллоор, горимын саналаар санал хураалт явуулъя. Энэ бол яах вэ гуравны хоёр гэдгээ баталгаажуулж байгаа л юу шүү дээ.

15 гишүүнээс 14 нь зөвшөөрч, 93.3 хувиар горимын санал дэмжигдлээ.

Одоо зарчмын зөрүүтэй саналаараа санал хураалт явуулна. Би энэ дээр товч тайлбарууд хэлье. Түрүүчийн хоёрдугаар хэлэлцүүлгээр санал хурааж, олонх дэмжсэн санал байгаа. Тэрийг өөрчлөх тухай зарчмын зөрүүтэй санал байгаа.

Томъёолол нь, Төслийн 1 дүгээр зүйл буюу Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсын Их Хурал нэг

танхимтай, нэг зуун хорин зургаан гишүүнтэй байна. Улсын Их Хурлын сонгуулийг олныг төлөөлөх болон хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоогоор явуулна. Улсын Их Хурлын далан зургаан гишүүнийг олныг төлөөлөх, тавин гишүүнийг хувь тэнцүүлэн хуваарилах сонгуулийн аргын үндсэн дээр сонгоно.” гэснийг “Монгол Улсын Их Хурал нэг танхимтай, нэг зуун хорин зургаан гишүүнтэй байна. Улсын Их Хурлын сонгуулийг сонгуулийн холимог тогтолцоогоор явуулна. Улсын Их Хурлын далан найман гишүүнийг олныг төлөөлөх, дөчин найман гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно.” гэж өөрчлөн найруулах. Санал гаргасан ажлын хэсэг.

Энэ саналыг Төрийн байгуулалтын байнгын хороонд оролцсон, хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар шийдвэрлэх ёстой. Саяын унисан томъёоллоор, гаргасан саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт. Тийм Байнгын хороонд оруулж байгаа учраас.

15 гишүүнээс 13 нь дэмжиж, 86.7 хувиар ажлын хэсгийн санал дэмжигдлээ.

Ер нь бол 3 хүртэл удаа санал хураах ёстой. Хоёр дахь удаагаа яг саяын томъёоллоороо санал хураана. Дахиад санал хураалт. Анхааралтай байгаарай гишүүд ээ.

15 гишүүнээс 15-уулаа дэмжиж, ажлын хэсгийн санал 100 хувиар дэмжигдлээ.

Холбогдох саналаар санал хурааж дууслаа. Гишүүддээ баярлалаа. Том асуудал шийдэж байна Байнгын хороогоор. Одоо Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Доржханд гишүүн танилцуулъя.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг Байнгын хорооны хуралдаанаар гурав дахь

хэлэлцүүлэгт бэлтгэж дууслаа.
Дараагийн асуудалдаа оръё.

10.52 цаг

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Танилцуулгыг би уншиж танилцуулъя. Ажлын хэсгийн гишүүдийг бас нэг сануулчихъя. Энхболд ахалсан. Тогтохсүрэн, Сарантуяа, Саранчимэг, Сарангэрэл, Доржханд, Батсуурь, Энхбаяр, Адьшаа, Нямбаатар нарын 9 гишүүн энэ ажлын хэсэгт орсон байгаа. 2 удаа хуралдсан тухайгаа түрүүн хэлсэн. Танилцсан болно. Ахиад, дахиад.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 23 оны 5 сарын 3-ны өдөр Улсын Их Хуралд Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөх шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Их Хурлын чуулганы 23 оны 5 сарын 19-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр, гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Улсын Их Хурлын 23 оны 37 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэг 2023 оны 5 сарын 26, 30-ны өдрүүдэд хуралдаж, нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд нэмж тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон ажлын хэсгийн танилцуулгыг та бүхэнд танилцуулж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 42.2.1 дэх

хэсэгт заасан гүйцээн боловсруулах чиглэлийн дагуу төслийн хоёрдугаар зүйлийг Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн дүнгээр байгуулагдах Улсын Их Хурлын бүрэн эрх хэрэгжиж эхлэх хүртэл 2020 оны ээлжит сонгуулийн дүнгээр байгуулагдсан Улсын Их Хурал бүрэн эрхээ хэвээр хадгална гэж өөрчлөх саналыг ажлын хэсгээс гаргасан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.3 дахь хэсэгт заасны дагуу хураалгахаар 2 зарчмын зөрүүтэй санал бэлтгэж Байнгын хороонд оруулж байна. Саналыг та бүхэнд тараасан байгаа.

Ийм учраас Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулга, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Ажлын хэсгээс Байнгын хороонд оруулж байгаа танилцуулгатай холбогдуулаад асуулт асуух гишүүн байвал нэрээ өгье. Нямбаатар, Занданшатар нарын гишүүдээр тасаллаа. Нямбаатар гишүүн. Ажлын хэсгийн гишүүн өөрөө асуугаад байх шаардлага байна уу?

Х.Нямбаатар: Өчигдөр би харин, уучлаарай даргаа. Би өчигдрийн ажлын хэсгийн хуралд оройтоод. Энэ дээр зүгээр нэг л ийм асуудал байгаа юм. Энэ дагаж мөрдөх, Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын хуулийн 1 дүгээр зүйлийн агуулга, 5 дугаар зүйлийн агуулга хоёр яг ижил зүйлийг зохицуулаад байна. Тэгэхээр энэ өөрөө хууль зүйн техникийн хувьд энэ буруу байна.

Ийм учраас 5 дугаар зүйлийг нь аваад хаячихъя, хасъя гэсэн ийм л саналыг хэлэх гэж байгаа юм. Тийм.

Н.Энхболд: Тийм санал гарч байгаа юм байна. Ажлын хэсгээс оруулан тэр тавыг хасна гэж байхгүй байгаа. Ер нь бол зүгээр 1 дүгээр заалт бол Үндсэн хуульд оруулсан өөрчлөлт маань дагаж мөрдөх хугацааны тухай, 5 дугаар заалт бол энэ Шилжих журмын тухай хууль хэзээнээс дагаж мөрдөхийг заасан ийм хоёр тусдаа ойлголт байгаа шүү. Энэ дээр бас гишүүд саналаа өгөхдөө бодно биз. Занданишатар дарга.

Г.Занданишатар: Энэ Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн эхний хэлэлцүүлгийн үеэр хожим үүсэж болзошгүй Үндсэн хуулийн маргаан гарах эрсдэлийг хаах зорилгоор.../ үг тасрав.

Н.Энхболд: Гишүүд ээ чимээгүй сонс доо ярьж байгаа юмыг. Дараа нь яриарай.

Г.Занданишатар: Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг үндэслэн олныг төлөөлөх гэдгийг мажоритар гэж хаалтад хийгээд, хувь тэнцүүлэн хуваарилах гэдгийг пропорциональ гэж хаалтад хийгээд энэ 2 үгийг үндсэндээ Үндсэн хуульд заавал тусгах шаардлагатай гэж байсан агуулга хэлж байгаа. Дагаж мөрдөх журмын тухай хуульдаа энэ үгийг ингэж монголчилж байгаа Монгол үг зүй, хэл зүйн найруулгын хувьд ингэж оруулж байгаа гэдгээ баталгаажуулчихъя гэж тохироод оруулсан.

Тэгэхдээ сая оруулсан өөрчлөлтийн дагуу энэ 2 үгийг, гадаад үгийг хасаж байгаа учраас Үндсэн хууль тогтоогчид болон холбогдох хууль зүйн байгууллагуудтай зөвлөлдсөний үндсэн дээр энэ асуудлыг нэг мөр ингэж ойлгож байгаа гэдгээ Байнгын хороо болон чуулганы тогтоол дээр протоколд

тусгах зорилгоор тэмдэглээд энийг шаардлагатай бол санал хураалтаар баталгаажуулаад, энэ олныг төлөөлөх гэж мажоритар тогтолцоогоо хэлж байгаа юм байна. Пропорциональ гэж хувь тэнцүүлэх тогтолцоогоо монголчилж Монгол нэр томъёо ашиглаж байгаа юм байна гэдгээ бас албан ёсоор тэмдэглэж, протоколд үлдээж байна.

Хожим бол олныг төлөөлөх, олонхыг төлөөлөх Цэц дээр болон олон жилийн дараа энэ чинь олон жил мөрдөгдөх учраас үүсэж болзошгүй маргаанд тайлбар өгөх зорилгоор протоколд энийг тэмдэглүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Ийм учраас төсөл санаачлагчаас өргөн мэдүүлсэн мажоритар гэдэг үгийг олныг төлөөлөх, пропорциональ гэдэг үгийг бол хувь тэнцүүлэх, хувь тэнцүүлэн төлөөлөх гэдэг агуулгаар оруулж байгаа гэдгийг энд эхний хэлэлцүүлгийн үед яригдсан бөгөөд эхний хэлэлцүүлэг дээр энэ үгнүүд хасагдаж байгаа учраас протоколд зориуд тэмдэглэн үлдээж байна.

Энийг хэрвээ шаардлагатай бол санал хураалтаар баталгаажуулаад үлдээх нь зүйтэй байх. Хожим үүсэж болзошгүй аливаа маргаанаас урьдчилан сэргийлэх зорилгоор. Энэ чинь цаашдаа сонгуулийн маргаан болж хувирч болзошгүй учраас ингэж ойлголоо. Энэ үг зүй, Үндсэн хуулийн үг зүй, агуулга, техникийн хувьд энийг Үндсэн хууль тогтоогчдоос ирүүлсэн саналыг бас уламжилж, тэмдэглэж байгаа юм.

5 дугаар зүйлийг бол хасна гэдэг Нямбаатар сайдтай санал нэг байна. Энд хасагдаж байгаа гэж ойлголоо. Энд санал хураалт дээр тэгэхдээ алга байгааг анхаарна биз.

Н.Энхболд: Баярлалаа. Занданишатар даргын хэлснийг анхааралдаа авлаа. Байнгын хорооны

санал, дүгнэлтэд зориуд биччихье. Тэгээд протоколд бас нэмэлтээр зориуд тусгаад ингээд яваг гэж бодож байна. Бид нар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтдээ нэмээд оруулчихъя.

Гишүүд асуулт тавьж дууслаа. Санал, асуулт хамт явчихлаа даа. Одоо шууд санал хураалтдаа оръё.

Тогтохсүрэн дарга санал хэлэх гээд байна уу, үгүй юу. Юу гэнээ? Одоо тайлбарлачихъя шаардлагагүй гэж үзвэл. Тийм. Дахиад түрүүнд горим явсан. Саналуудаа гуравны хоёрын дэмжлэгээр батална. Чуулганы дэгийн тухай хуульд заасны дагуу 42.2.3-д нэгдсэн хуралдаанаар, Пүрэвдоржсоо чи чимээгүй бай л даа. Энэ гишүүд анхаарахгүй байж байгаад буруу, зөрүү саналаа өгчих юм бол. Чи наад юмаа дараа нь ярь за юу. Тийм.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн бол саналуудыг гуравны хоёроор хэлэлцэж дэмжиж, дэмжихгүйгээ илэрхийлнэ гэсэн байгаа.

Түрүүн бид нар санал хураачихсан. Бүх асуудлуудаа. Тэрэнтэй адилхан энэ хууль дээр гуравны хоёрын саналаар асуудлуудаа дэмжээд явъя гэсэн горимын санал оруулж байна. Санал хураалт. Дэгт байгаа ч гэсэн баталгаажуулаад л яваад байгаа юм шүү. Тийм.

15 гишүүнээс 15, 100 хувийн саналаар горимын саналыг дэмжлээ. Одоо зарчмын зөрүүтэй санал хураалтуудаа эхэлье.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд ишлжих журмын тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн улс орон даяар дагаж мөрдөнө.”

Ингээд санал хураачхаад дараа нь би тайлбар хэлнэ. Санал хураалт.

15-аас 15 дэмжиж, 100 хувиар дэмжигдэж байна.

Энэ 1 дүгээр заалт дэмжигдсэнтэй холбоотойгоор хоёрдугаар хэлэлцүүлгээс гарсан 5 дахь заалт үндсэндээ санал хураалгах шаардлагагүй гэж үзээд төслөөс нь хасъя гэсэн саналаар санал хураалт явуулья.

4 дүгээр заалт байгаа шүү дээ. Энэ хууль Үндсэн хуулийн адил хүчин төгөлдөр гэсэн.

Тэгээд өөрийн чинь саналаар хасагдчихлаа шүү дээ наад ярьж байгаа юм чинь. Тэгээд нэг дор 2 өөр саналууд гаргаад байж болохгүй шүү дээ. Тийм. Ажлын хэсэг дээр байсан гишүүд өөрснөө ингээд дахин дахин өөр өөр саналууд гаргаад байх юм. Өчигдөр явахдаа та өөрөө за би бүх зүйлээ дэмжиж байгаа гэж хэлээд явсан. Тэрний дагуу бид нар санал хураагаад шийдсэн. Тэгээд хэрэв тэр тэгэхдээ ажлын шаардлага гарсныг ойлгосон, ойлгосон тийм. Ажлын шаардлага гаргасныг ойлгосон. Тэгвэл одоо ингэе Нямбаатараа хүлээж бай. Тэгээд тэр 5 дугаар заалт нь хэвээрээ үлдэнэ л гэсэн үг байх биз дээ тэгэхээр чинь. Занданшатар дарга үг хэлье.

Г.Занданшатар: Үндсэн хууль хэлэлцэж байгаа учраас долоо хэмжиж нэг огтлох зарчмаар аль болох алдаа мадаггүй хийх нь зөв л дөө. Тийм учраас эхний хэлэлцүүлгийн үеэр чинь бид нар

ярьж ярьж байгаад 6.13 гэхээр, 6.13-д зааснаар гэхээр Ерөнхийлөгч нотлон баталгаажуулах болсноор хүчин төгөлдөр болох юм шиг агуулга болоод байна гэж байгаад 6.14 болгоод, тэгээд хүчин төгөлдөр болох хугацаагаа уул нь их тодорхой болгож байсан байхгүй юу. Одоо энэ 5 дугаар зүйл сэргэлээ ч гэсэн тэр чинь хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө л гэж байгаа болохоос биш хүчин төгөлдөр болох хугацаагаа тодруулж өгөхгүй байгаа юм. Тийм учраас ердийн журмаар явна гэхээр бас хуульчдын дунд маргаан сул гараад байх вий. Хэвлэн нийтлэгдсэнээс хойш 7 хоногийн дараа ингээд ердийн хууль шиг энэ тэр, ердийн журмаар явах болчихоор ердийн хууль шиг үзэх үү, үгүй юү хууль гээд биччихсэн бас тал байгаа шүү дээ. Журамд өөрчлөлт оруулах журмын тухай хуулиар.

Тэгээд хойшоо хөөцлөгдөөд 6 сарын 15-н болоод Сонгуулийн хуульд өөрчлөлт оруулахаар дагаж мөрдөх хугацаа энэ тэр чинь тийм хууль зүйн техникийн хувьд тийм хайч гарчих вий гэдэг бас Нямбаатар сайдын болгоомжлол бол үндэслэлтэй байгаа учраас энийг бас эцсийн хэлэлцүүлэг учраас 6.13 гэдгээр аваачаад явчихад бас болохоор л байсан юм. Тэрийг Бямбадулам, Хатантуул хоёр үзээдхээч тэгэх үү.

Н.Энхболд: Энэ дээр хэрэв саналууд Байнгын хороон гишүүдээ бол сая хамгийн сүүлд хураасан саналаа хүчингүй болгочоод 5 дугаар заалт дээр очингуутаа эргээд тэрийгээ дэлгэрүүлээд нэг ярьчихъя. 1 бишээ, 1-ээ баталчихсан шүү дээ бид нар. 1-тэй холбогдуулаад 5 гэж хураагаад сая хүчингүй болгочихгүй юу. Тэгээд тэрийгээ буцааж хүчингүй болгоод, 5 дээрээ очоод саяынхаа асуудлыг ярьчихъя. Тийм за.

Сая 1 дүгээр зүйлийг дэмжсэнтэй холбогдуулаад 5 дугаар зүйлийг хасъя гэсэн томъёоллоор санал хураасан дэмжигдсэн уг нь. Тэгэхдээ ийм

асуудлууд гарч байгаа учраас хамгийн сүүлд хураасан тэр саналаа хүчингүй болгоё гэсэн томъёоллоор дахиад санал хураалт явуулчихъя. Санал хураалт.

Эргээд хүчингүй болгож болно л доо.

15-аас 14 дэмжиж тэр санал хүчингүй боллоо. Тэрийг тэн дээрээ очиж байгаад саналаа хураахдаа ярьчихъя.

2.Төслийн 3 дугаар зүйлийн “2023 оны дугаар сарын тэдний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөд нийцүүлэн холбогдох хуулийг шинэчлэн батлах хүртэл хугацаанд тухайн харилцааг зохицуулж ирсэн хуулийг дагаж мөрдөнө. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг үндэслэн олныг төлөөлөх хаалтад мажоритар, хувь тэнцүүлэн хуваарилах хаалтад пропорционал тогтолцоог хослуулан явуулах зохицуулалтад Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг нийцүүлэх ажлыг Улсын Их Хурлаас баталсан хуваарийн дагуу хэлэлцэн шийдвэрлэнэ.” гэж хоёрдугаар хэлэлцүүлгээр дэмжсэн байсан саналыг “2023 оны 5 дугаар сарын тэдний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөд нийцүүлэн холбогдох хуульд өөрчлөлт оруулах болон шинэчлэн батлах хүртэл хугацаанд тухайн харилцааг зохицуулж ирсэн хуулийг дагаж мөрдөнө. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөд нийцүүлэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг 2023 оны 6 сарын 25-ны дотор, холбогдох бусад хууль тогтоомжийн өөрчлөлтийг Улсын Их Хурлаас баталсан хуваарийн дагуу хийж дуусгана.” гэсэн ажлын хэсгийн санал байна.

Гуравны хоёроор явна. Дахид горимоор санал хураалгах ёстой юм байна. Саяын заалтыг гуравны хоёроос доошгүйн саналаар дэмжинэ гэсэн горимын саналаар санал хураалт явуулъя.

15 гишүүнээс 14 нь дэмжиж, горим санал дэмжигдэж байна. Тэгээд саяын уншсан томьёоллоор санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

15-аас 15 хүн дэмжиж, 100 хувь боллоо. Энэ дагаж гарах хуулиудын тухай асуудал шүү дээ Занданиатар даргаа. Энэ дотроос хамгийн гол нь Сонгуулийн хуулиа эхлээд 25-ны дотор батлаад, бусад хуулиудаа бол шаардлагатай хугацаануудад нь батална гэсэн гурав дахь удаагаа ярьж байгаа заалт шүү дээ энэ чинь. Тийм. Тэгнэ.

Тэрнээс нааш сонгууль болохгүй шүү дээ. 1 сарын, дараа оны 2 сараас эхлээд сонгуулийн ажлууд яригдаж ирнэ. Бид нар 1 сарын 1 гэхэд. Хуулиа 6 сарын 25-нд баталчихна Сонгуулийн хуулиа тийм ээ. Хэрэгжиж эхлэх хугацаа нь 1 сарын 1-нээс байхгүй юу.

Тэгнэ шүү дээ. Энэ Үндсэн хуулийг, Үндсэн хуулийг дагаад гарч байгаа бусад хуулиуд хэзээнээс мөрдөгдөх вэ, хэзээ батлах вэ гэдгийг л зохицуулсан хууль, заалт байгаа юм.

Ялгаа юу байна. Хэрэглэж эхлэх хугацаа нь он гарч байж л хэрэглэнэ шүү дээ тэр хуулиуд чинь.

Бид нарын ажлын хэсэг дээр ярьснаар бол өмнө гарсан нэмэлт, өөрчлөлттэй холбоотой дагаж гарч байсан хуулиуд яг ийм үгээр л гарч байсан л даа. Тэндээс бол ямар нэгэн зөрчил үүсээгүй. Тийм тийм.

Тухайн үед гарсан хуулиуддаа мөрдөх хугацааг нь тусгайлаад заагаад явж болно гэж ажлын хэсэг дээр үзсэн гэж ойлгож байгаа. Тийм.

Дараагийн заалт дээрээ оръё. Явчихсан шүү дээ сая. Горимоор явсан уу.

19 оны нэмэлт, өөрчлөлтийн дараа яг ийм үгээр орсон юм. Тийм. Зөрчил үүсээгүй. Тэр хооронд мөрдөх хугацаагаа тэр хууль дээрээ өөр дээр нь заачхаж болно шүү дээ Сүхээ гишүүнээ. Тийм.

Одоо зарчмын зөрүүтэй саналаараа санал хураалт явна. Сая горимоор хураасан.

Саяын томьёоллоор энэ саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Нямбаатараа.

15-аас 15 гишүүн дэмжиж, 100 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Дараагийн асуудал гишүүдээ анхааралтай сонсоорой. Үгүй ээ, энэ чинь энэ хуулийг биш энэний дагуу дараа нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт орсныг дагуулж гарах дараа ярих хуулиудын тухай яриад байгаа заалт шүү дээ даргаа. Тийм биз дээ. Тийм.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.1 дэх хэсэгт заасны дагуу гүйцээн боловсруулах чиглэл өгсний дагуу хураалгах зарчмын зөрүүтэй санал байна. Томьёоллыг нь уншиж танилцуулъя.

Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн дүнгээр байгуулагдах Улсын Их Хурлын бүрэн эрх хэрэгжиж эхлэх хүртэл 2020 оны ээлжит сонгуулийн дүнгээр байгуулагдсан Улсын Их Хурал бүрэн эрхээ хэвээр хадгална.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

15-аас 14. Нямбаатар гишүүнээс бусад нь дэмжлээ. 93.3 хувиар санал дэмжигдлээ.

Ажлын хэсгээс боловсруулсан зарчмын зөрүүтэй саналуудаар санал хурааж дууслаа.

5 дугаар зүйл байгаа шүү дээ. 5 дугаар зүйлээ яах вэ гэдгээ ярьчихъя.

Ийм шүү дээ Нямбаатар сайдаа хоёрдугаар хэлэлцүүлгээр хөндөгдөөгүй асуудлыг бид нар одоо энэ дээр ярьж болохгүй байх. Тэгээд үлдэхээс өөр арга байхгүй. Тэгвэл тэр чигээр нь орхиод л 5 хэвээрээ үлдэнэ гэсэн үг шүү дээ тийм ээ. Ингээд гүйцээ тийм тийм.

Амарсайхан сайд.

С.Амарсайхан: Нэг асуудал байна. Даргаа энэ Дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хууль чинь Үндсэн хуулийн хавсралт гэдгээрээ өмнө нь бид нар ярьснаар явах гэж байна уу. Эсвэл энэ Монгол Улсын хууль гэдгээр явах гэж байна уу. Энэ нэг ийм ойлгомжгүй асуудал байгаад байна.

Яагаад гэхээр бид нар Монгол Улсын хууль гэж явах юм бол ердийн олонхоор баталсан хууль. Гэтэл энэ Дагаж мөрдөх журмын тухай хуулийн, шилжих журмын тухай хуулийн чинь 4 дээр Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт нэгэн адил хүчинтэй гэж. Хэрвээ хавсралт бишээр явж, бишээр Монгол Улсын хууль гээд явбал энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй нэгэн адил хүчин төгөлдөр байх ямар ч боломжгүй асар том зөрчилдөөн үүсээд явна. Тийм.

Тэгэхээр энийг яг энэ Монгол Улсын хууль гээд энүүгээрээ явах гэж байна уу, хавсралт гэдгээрээ явах гэж байна уу гэдгийг тодруулах хэрэгтэй.

Н.Энхболд: Ийм юм Амарсайхан сайдаа 4 дүгээр зүйл бол хоёрдугаар хэлэлцүүлгээр санал хураагдсан гурвын хоёроор байсан дандаа. Байнгын хороон дээр ч гурвны хоёроор явсан. Одоо дахиад Их Хурлаар орохдоо ч гэсэн бид нар

гуравны хоёроор санал хураана. Тэгж байж тэр легитим Үндсэн хуультай адил хүчинтэй байх. Тийм дөрөвний гурваар, дөрөвний гурваар Их Хурал дээр тийм. Байнгын хороон дээр бол тэр журмаар явсан.

Тийм учраас энэ тэнд хөндөгдөөгүй. Дэг нь бол яг Үндсэн хуультай адилхан хураагдаад явчихсан байж байгаа. Үгүй энэ түрүүчийн юмнууд ч гэсэн дандаа ингэж Дагаж мөрдөх журам дээрээ албан ёсоор Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй адил хүчинтэй гэдэг юмаараа ингээд яваад тогтчихсон юм байна лээ тэх.

Ажлын хэсэг, Тамгын газар чуулганы нэгдсэн хуралдаанд ороход энэ саналуудыг яаж хураасан байдлаар асуулт гарвал танилцуулахад бэлдсэн, хариугаа бэлдсэн, санал хураалтын дүнг ямар горимоор хураасан, ямар дүн гарсан гэдгийг бэлдсэн байгаарай. Асуулт гарвал хариулья.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Оюунчимэг танилцуулна.

Төрийн байгуулалтын байнгын хорооны хэлэлцэх асуудал дууслаа. Энэ өдрийн хуралдаан хаасныг мэдэгдье. Гишүүд, ажлын хэсгийнхэндээ баярлалаа.

11.20 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР

